



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 259

Улаанбаатар хот

Үнэт цаас гаргагчид үйлчилгээ
үзүүлэх аудитын компаниар бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 2012 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай” журмын 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:


1. Дор дурьдсан нэр бүхий компаниудыг үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудитын компаниар 3 жилийн хугацаагаар бүртгэсүгэй.

- 1/ “Конфиденс-Аудит” ХХК;
- 2/ “Итгэлт-Аудит” ХХК;
- 3/ “Далайван-Аудит” ХХК;
- 4/ “Прайсуотерхаускуперс-Аудит” ХХК;
- 5/ “Эс Эм-Аудит” ХХК;
- 6/ “Сүлд-Аудит” ХХК;
- 7/ “Тэд-Аудит” ХХК.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг дээрх нэр бүхий компаниудын захирлуудад үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН